



БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023-2024

*Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа эрхэм зорилго, стратегийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын бүтэц зохион байгуулалт, хяналт шинжилгээ-үнэлгээ хийх аргачлалыг тусгав.*

## АГУУЛГА

Өмнөтгөл		
НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5-6
ХОЁР.	МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	7-13
ГУРАВ.	АЛСЫН ХАРАА	14
ДӨРӨВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО	14
ТАВ.	ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	15-26
ЗУРГАА.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	27
ДОЛОО.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА НИЙСЛЭЛИЙН БҮТЦИЙН УЯЛДАА	27-29
НАЙМ.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН	30-34
ЕС.	НИЙСЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ	35-37

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.	Нийслэлийн өмчийн харилцааны газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар
ХҮСНЭГТ 2.	Нийслэлийн өмчийн харилцааны газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар
ХҮСНЭГТ 3.	Холбогдогч талуудын оролцоо
ХҮСНЭГТ 4.	Нийслэлийн өмчийн харилцааны газрын чиг үүргийн хэрэгжилт, хувиар
ХҮСНЭГТ 5.	Дотоод орчны шинжилгээ
ХҮСНЭГТ 6.	Гадаад орчны шинжилгээ
ХҮСНЭГТ 7.	Стратегийн зорилго зорилт шалгуур үзүүлэлтүүд
ХҮСНЭГТ 8.	Стратегийн зорилго 1
ХҮСНЭГТ 9.	Стратегийн зорилго 2
ХҮСНЭГТ 10.	Стратегийн зорилго 3
ХҮСНЭГТ 11.	Стратегийн зорилго 4
ХҮСНЭГТ 12.	Стратегийн зорилго 5

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.	Холбогдогч талуудын зураг
ЗУРАГ 2.	Бүтцийн схем зураг

## ӨМНӨТГӨЛ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 06 дугаар сараас мөрдөгдөж эхэлсэн. Уг хуульд “Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна” гэж заасан.

Нийслэлийн хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” байна. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Ингэхдээ нийслэл болон түүний харьяа байгууллагууд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах юм.

Иймд Нийслэлийн нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг боловсруулахаар Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/90 дүгээр захирамжаар “Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажлыг зохион байгуулан төслийг боловсруулсан.

Нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд шаардлагатай өгөгдөл мэдээллийг баримт бичиг судлан аргаар цуглуулсан. Ингээд стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу Нийслэлийн стратеги төлөвлөгөөг дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилго ба бүтцийн уялдаа
8. Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин
9. Стратегийн зураглал

**Нэг.** Нийтлэг үндэслэл хэсэгт Нийслэлийн Өмчийн харилцааны газрын стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг холбогдох эрх зүйн баримт бичгийг судлах байдлаар тодорхойлсон.

**Хоёр.** Мандатын шинжилгээг хийхдээ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүргийг тодорхойлсон холбогдох эрх зүйн баримт бичигт судалгаа, шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын чиг үүргийг холбогдох эрх зүйн баримт бичгээс түүвэрлэн авч, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, нийслэлийн ерөнхий, үндсэн, дэд чиг үүргүүдийг тодорхойлов. Ингэхдээ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006), мөн УИХ-аас 2020 онд баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль тогтоомжийг үндэслэсэн. Ялангуяа, Нийслэлийн ерөнхий болон үндсэн чиг үүргийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006, 2020), “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (1994)”-нд тулгуурлан тодорхойлсон. Харин дэд чиг үүргийг тодорхойлохдоо Салбарын хуулиуд болон Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүргийн шинжилгээний тайланг<sup>1</sup> үндэслэв.

2. Нийслэлтэй Өмчийн харилцааны газрын харилцдаг холбогдогч талууд, тэдгээрийн оролцоог тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Засаг даргаас бусад хуулийн этгээд, байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Харин эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлж хүснэгтэд нэгтгэсэн.
3. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хууль журмаар олгосон чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг баримт бичгийн судалгааны үр дүн болон холбогдох баримт материалд тулгуурлан тодорхойлсон.
4. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын эрх хэмжээг “захиргааны эрх хэмжээний ангилал” болох бодлого боловсруулах, зохицуулалт хийх, санхүүжүүлэх, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх гэсэн ерөнхий чиглэлээр нь ангилан хүснэгтэд нэгтгэн харуулсан.

**Гурав.** Нийслэлийн алсын харааг тодорхойлохдоо ажлын хэсгийн гишүүд, зөвлөх багийн гишүүдээс ирсэн саналыг үндэслэн боловсруулсан.

**Дөрөв.** Нийслэлийн Өмчийн харилцааны газрын эрхэм зорилгыг тодорхойлохдоо байгууллагын дүрэмд тулгуурлан ажлын хэсгийн гишүүд, зөвлөх багийн гишүүдээс ирсэн саналыг үндэслэн боловсруулсан.

**Тав.** Орчны шинжилгээний үндсэн зорилго нь нийслэлийн Өмчийн харилцааны газрын нөхцөл байдлыг судалж, үр дүнг байгууллагын 2023-2024 оны стратегийн шийдвэрийн гол үндэслэлийг томъёолоход суурь болгон ашиглах юм. Өөрөөр хэлбэл, гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх замаар хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно.

Аливаа стратегийн шинжтэй шийдвэр гаргах, төлөвлөгөө боловсруулахын тулд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг дотоод, гадаад орчныг судлах шаардлагатай болдог бөгөөд байгууллагын алсын хараа, урт хугацааны зорилтууд, стратегийн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлоход CBOT шинжилгээг ашиглалаа.

Орчны шинжилгээг хийхдээ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлоход голлон чиглэсэн ба өнгөрсөн жилийн тайлан, жил, улирлын гүйцэтгэлийн, төсөв санхүүгийн тайлангууд болон мандатын шинжилгээний хүрээнд хийгдсэн гадагш, дотогш чиглэсэн харилцааны хүрээнд холбогдогч талуудыг тодорхойлон одоогийн дүр төрхийг тодорхойлж, давуу ба сул тал, боломж, аюул заналаар дамжуулан цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлон гаргасан.

**Зургаа.** Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөө боловсруулах хүрээнд нийт 5 стратегийн зорилго тодорхойлсон.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1-д “Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэж заасны дагуу “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тулгуурлан 5 үндсэн чиглэл буюу зорилгод үндэслэн тодорхойлсон.

**Долоо.** Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хувьд тодорхойлсон стратегийн зорилгуудыг холбогдох байгууллага, нэгжийн үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулан зураглан үзүүлж, шаардлагатай тайлбарыг бичсэн. Өөрөөр хэлбэл, стратегийн зорилгуудын хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох үүднээс зорилго ба бүтцийн уялдааг зургаар илэрхийлж, гүйцэтгэх үүргийг товч тайлбар хэлбэрээр оруулсан.

**Найм.** Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөний 5 стратегийн зорилгын хүрээнд 36 зорилт, 36 стратеги, 89 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлсон.

Стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин тодорхойлохдоо:

1. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн, үйл ажиллагаа, гарцад бус үр дүнд чиглүүлэн тодорхойлохыг зорьсон. <sup>2</sup>
2. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулан тодорхойлохыг зорьсон.
3. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны биелэлтээс зорилтын биелэлтийг тооцох, зорилтын биелэлтээс зорилгын биелэлтийг тооцон гаргах арга зүйг ашигласан.

## НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад өмчийн олон хэлбэр үүсэж бий болсон 1990-ээд оноос өмчийн харилцааны салбарыг манлайлж, газар болон байгалийн дагалдах нөөцийн үнэлгээ тогтоох, өмч хөрөнгийг түрээслүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг ажлын байраар хангах, төрийн төлөөллийг төрийн өмчийг эзэмшигч байгууллагууд, төрийн өмчийн оролцоотой болон хамтарсан компаниудад хэрэгжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлж гүйцэтгүүлэх, төрийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийлгэх, өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулан, үр өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар газрын төлбөр, түрээс, өмч хувьчлалын орлого, ногдол ашгийг төсвийн орлого бүрдүүлдэг үндсэн эх үүсвэр болгох зэрэг өмчийн харилцааны хөгжлийн явц дахь олон өөрчлөлт, шинэчлэлтийн анхдагч болсон.

Өмчийн харилцааг зохицуулах талаар зохих хууль, журам батлагдаагүй, туршлага хуримтлагдаагүй нөхцөлд ажлын гараагаа эхлүүлж байсан бол өнгөрсөн хугацаанд холбогдох хууль, дүрэм, тогтоол шийдвэрийг батлуулан, өмчийн харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлж, нийслэл дэх өмчийн харилцааг зохицуулах ажлыг амжилттай зохион байгуулж ирсэн.

Өмчийн харилцааны газар нь концессын ажлыг хэрэгжүүлж эхэлснээр төсөвт тусгагдаагүй их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай зам талбай, барилга байгууламжуудыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр бариулах, менежментийн нь тодорхой нөхцөлийн дагуу боловсронгуй болгон ашиглуулах, эзэмшүүлэх замаар төрөөс нийслэлийн иргэдэд хүргэн дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн сайжруулахад чиглэгдсэн өмчийг хувьчлахгүйгээр нийслэлийн өмчид хувийн хөрөнгө оруулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, дэд бүтцийн салбарт төсвийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтыг багасган, нийслэлийн төсвийн ачааллыг бууруулах үндэс суурь тавигдсанаар түүхийн шинэ үеийг эхлүүлсэн.

Энэхүү амжилт бүтээл нь газрын үе үеийн удирдлага, ажилтан, ажиллагсад, нийслэлийн өмчийг эзэмшигч болон хамтран ажиллагсад байгууллагуудын идэвх чармайлт, бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн. Өнгөрсөн хугацаанд манай хамт олон хийж бүтээснийхээ хирээр туршлага хуримтлуулж, өмчийн харилцааны талаар зохих мэдлэг боловсролтой ажилтан, ажиллагсад бүхий мэргэшсэн баг ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга)-ийн 53.1-д зааснаар “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж тусгасан. Энэ хүрээнд “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” батлах тухай Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, мөн

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг шинэчлэн баталсан. “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулахаар тусгасан.

Иймд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг үндэслэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүсэж байна.

Өмчийн харилцааны газар нь хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд 2023-2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд буй арга хэмжээгээ хэрэгжүүлэхдээ төр, иргэний ашиг сонирхлыг дээдлэн, тэдний оролцоог ханган ажиллаж гүйцэтгэлийн үр дүнгийн талаар жил бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүрсэн түвшнийг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал, эрсдэлийг бууруулж, давуу тал, боломжийг ашиглан, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг ханган биелүүлэх, Засаг даргаас шийдвэр гаргахад мэргэжлийн арга зүй, санал зөвлөмжөөр хангаж ажиллахаас гадна газрын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар иргэдэд ил тод нээлттэй мэдээлэн ажиллаж байх болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь төрийн байгууллагын хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд тусгаснаар “чиг үүрэг” гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл юм.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг тус тус мөрдлөг болгосон. Ийнхүү Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мандатын шинжилгээг дараах алхмуудын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Алхам 1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүргийг тодорхойлох;

Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, НЗД-ын 2021 оны А/1040, А/1059 дүгээр захирамжаар баталсан бүтэц, НЗД-ын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/75 дугаар захирамжаар батлагдсан НӨХГ-ын дүрмийг тус тус үндэслэн боловсруулав.

Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.16-д зааснаар Нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Өмчийн харилцааны газрыг ажиллуулахаар тогтоосон.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаанд хамаарах ерөнхий болон үндсэн чиг үүргийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-д тулгуурлан тодорхойлсон болно. Харин Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаанд хамаарах дэд чиг үүргийг тодорхойлохдоо салбарын дүрэм, журмыг мөрдлөг болгов.

Иймд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүргийг зөвхөн дүрэм, журамд тусгасан байдлаар авч үзлээ. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүрэгтэй холбоотой дүрэм, журмыг үзвэл 7 үндсэн чиг үүрэг 26 дэд чиг үүрэг” байна. үүнийг дараах хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харуулав.



**Хүснэгт 1. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны ангиллаар**

Салбарын ажиллагаанд мөрдөгдөж хуулийн тоо		үйл байгаа	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай Иргэний хууль Компанийн тухай Хөдөлмөрийн хууль
Үүнээс:	Тухайн салбарын хууль		Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
	Нийтлэг мөрддөг хууль		Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
<b>1. (ТБОНӨТХ 18, 19 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл Хөдөлмөрийн хуулийн 65 дугаар зүйл, Иргэний хуулийн 32 дугаар зүйл)</b>			
	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх оролцогчид
1.1	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн эд хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах, засаглалыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх	(НИТХТ-ийн 2014 оны 54 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зорилтот түвшнийг батлуулах, захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний биелэлт дүгнэх ажлыг зохион байгуулах	Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд
1.2		Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг судлан холбогдох шийдвэрийг гаргуулах	-
1.3		Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, сайн засаглалыг нэвтрүүлэх	Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд
1.4		Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах санал боловсруулан холбогдох шийдвэр гаргуулах	НЗДТГ
<b>2. ТБОНӨТХ 81 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл</b>			
2.1	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах	(НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах жагсаалт батлуулах, хувьчлалын арга хэлбэрийн талаар шийдвэр гаргуулах, хувьчлалын ажлыг зохион байгуулах, нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх	НЗДТГ
2.2		(НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоол) Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг зохион байгуулах	НЗДТГ
<b>3. ТБОНӨТХ 80, 77, 75, 76 дугаар зүйл, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.11, 12 дугаар зүйл</b>			
3.1	Нийслэлийн өмчит байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшил, захиран зарцуулалттай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах	(НИТХТ-ийн 2014 оны 66, 68 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах	НЗДТГ
3.2		ТБОНӨТХ 77.2.2 дугаар зүйл Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллого, дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах	-
3.3		(НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол)	-

		Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх	
3.4		НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр, талбайн түрээслэх ажлыг зохион байгуулах, нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх	-
<b>4. (ТБОНӨТХ 77.2.1 77.2.4, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2 дугаар зүйл, МУНУБХЭЗБТХ 12.1, 2 дугаар зүйл) Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих</b>			
4.1	Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих	(НӨХГ-ын дүрмийн 4.1 дүгээр 4.1.2, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12) Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах	-

### Нийслэлийн Засаг даргад олгосон захиргааны эрх хэмжээ

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд заасны дагуу Нийслэлийн Засаг даргын эрх хэмжээг тодорхойлохдоо дараах ангиллыг баримтлав. Үүнд:

**Зохицуулалт хийх:** Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

**Зохион байгуулах:** Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.

**Санхүүжилт:** Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.

**Хяналт шинжилгээ, үнэлгээ:** Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

**Үйлчилгээ үзүүлэх:** Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

### ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛЛААР

№	Чиг үүрэг	Захиргааны хэм хэмжээ				
		Зохицуулах	Зохион байгуулах	Санхүүжүүлэх	Үйлчилгээ үзүүлэх	Хяналт тавих
<b>1. (ТБОНӨТХ 18, 19 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл Хөдөлмөрийн хуулийн 65 дугаар зүйл, Иргэний хуулийн 32 дугаар зүйл) Нийслэлийн өмчит болон өмчийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн эд хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах, засаглалыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх</b>						
1.1	(НИТХТ-ийн 2014 оны 54 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зорилтот түвшнийг батлуулах, захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний биелэлт дүгнэх ажлыг зохион байгуулах	+	+		+	+

1.2	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг судлан холбогдох шийдвэрийг гаргуулах	+	+		+	+
1.3	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, сайн засаглалыг нэвтрүүлэх	+	+		+	+
1.4	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах санал боловсруулан холбогдох шийдвэр гаргуулах	+	+		+	+
<b>2. ТБОНӨТХ 81 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах</b>						
2.1	(НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах жагсаалт батлуулах, хувьчлалын арга хэлбэрийн талаар шийдвэр гаргуулах, хувьчлалын ажлыг зохион байгуулах, нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх	+	+		+	+
2.2	(НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоол) Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг зохион байгуулах	+	+			+
<b>3. ТБОНӨТХ 80, 77, 75, 76 дугаар зүйл, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.11, 12 дугаар зүйл Нийслэлийн өмчит байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшил, захиран зарцуулалттай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах</b>						
3.1	(НИТХТ-ийн 2014 оны 66, 68 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах	+	+		+	+
3.2	ТБОНӨТХ 77.2.2 дугаар зүйл Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллого, дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах	+	+		+	+
3.3	(НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх	+	+			+
3.4	(НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр, талбайн түрээслэх ажлыг зохион байгуулах, нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх	+	+		+	+
<b>4. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих (ТБОНӨТХ 77.2.1 77.2.4, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2 дугаар зүйл, МУНУБХЭЗБТХ 12.1, 2 дугаар зүйл)</b>						
4.1	(НӨХГ-ын дүрмийн 4.1 дүгээр 4.1.2, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12) Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах		+			+

Зураг 1. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОГЧ ТАЛУУД



## Хүснэгт 3. ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Бусад
Төр засгийн удирдах дээд байгууллага					√	
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨБЗГ		√	√	√	√	
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Ажлын алба		√	√	√	√	
Нийслэлийн Засаг дарга		√	√	√	√	
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар		√	√	√	√	
Нийслэлийн Захирагчийн Ажлын алба		√	√	√	√	
Нийслэлийн харьяа нутгийн захиргааны байгууллагууд	√	√	√	√	√	
Дүүргийн Засаг дарга	√		√			
Хэвлэл мэдээллийн байгууллага	√			√		
Олон улсын байгууллага	√		√	√		
Сургалт, судалгааны байгууллага	√		√	√		
Иргэд	√		√	√		
Аж ахуй нэгжүүд	√		√	√		
Төрийн бус байгууллага			√	√		
Ажилтнууд	√	√	√			
Өрсөлдөгчид	√		√	√		
Гаднын нийлүүлэгчид	√		√	√		

**Алхам 2. Холбогдогч талуудыг тодорхойлох.**

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх чиг үүргээс Нийслэлийн Өмчийн харилцааны газрын бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Үүнийг ерөнхий байдлаар авч үзвэл:

- 1) Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, зөвлөгөө дэмжлэг авах;
- 2) Хэвтээ чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах;
- 3) Доошоо чиглэлд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, санал, иргэдийн дуу хоолойг сонсох, үйлчилгээ үзүүлэх, эргэх холбоогоор хангах зэрэг хэлбэрээр харилцдаг болно. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт үзүүлэв.

**Алхам 4. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох.**

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ болон баримт бичгийн судалгааны дүнг үндэслэсэн.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг Засаг, даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд тусгаарлан тодорхойлсон. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар үзүүлэв.

**Хүснэгт 4. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУВИАР**

д/д	Чиг үүрэг	Чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ			
		МУХТ-4.4.1, НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1	2021 он	2022 он	Дундаж үнэлгээ (Хувиар)
<b>1. (ТБОНӨТХ 18, 19 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл Хөдөлмөрийн хуулийн 65 дугаар зүйл, Иргэний хуулийн 32 дугаар зүйл) Нийслэлийн өмчит болон өмчийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн өмчийн эд хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах, засаглалыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх</b>					
1.1	(НИТХТ-ийн 2014 оны 54 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зорилтот түвшнийг батлуулах, захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний биелэлт дүгнэх ажлыг зохион байгуулах	-		100%	
1.2	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг судлан холбогдох шийдвэрийг гаргуулах	100%		100%	
1.3	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, сайн засаглалыг нэвтрүүлэх			100%	
1.4	Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах,	100%		100%	

	татан буулгах санал боловсруулан холбогдох шийдвэр гаргуулах				
<b>2. ТБОНӨТХ 81 дүгээр зүйл, 77 дугаар зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.1.11, 35.1.12 дугаар зүйл Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах</b>					
<b>2.1</b>	Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах жагсаалт батлуулах, хувьчлалын арга хэлбэрийн талаар шийдвэр гаргуулах, хувьчлалын ажлыг зохион байгуулах	-		90%	
<b>2.2</b>	Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг зохион байгуулах	-		30%	
<b>3. ТБОНӨТХ 80, 77, 75, 76 дугаар зүйл, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйл, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2, 35.11, 12 дугаар зүйл Нийслэлийн өмчит байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшил, захиран зарцуулалттай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах</b>					
<b>3.1</b>	(НИТХТ-ийн 2014 оны 66, 68 дугаар тогтоол) Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах	-		100%	
<b>3.2</b>	ТБОНӨТХ 77.2.2 дугаар зүйл Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллого, дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах	-		100%	
<b>3.3</b>	(НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх	-		100%	
<b>3.4</b>	НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоол) Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр, талбайн түрээслэх ажлыг зохион байгуулах, нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх	-		97%	
<b>4. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих (ТБОНӨТХ 77.2.1 77.2.4, МУЗЗНДТУТХ 63.1.6, 24.1.2 дугаар зүйл, МУНУБХЭЗБТХ 12.1, 2 дугаар зүйл, байгуулах (НИТХТ-ийн 2014 оны 54, 55, 65, 66, 67, 68 дугаар тогтоол,</b>					
<b>4.1</b>	(НӨХГ-ын дүрмийн 4.1 дүгээр 4.1.2, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12) Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах	-		100%	

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ирээдүйн төлөвийг илэрхийлсэн, хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон үр дүн юм. Өөрөөр хэлбэл, алсын хараа нь амжилт дэвшилд хөтлөх уриа дуудлага бөгөөд нийслэлийн Өмчийн харилцааны газрын үйл ажиллагаа бүхэлдээ алсын хараанд чиглэнэ.



АЛСЫН ХАРАА:

Ёс зүйтэй, манлайлагч, мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болно

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн одоо ба ирээдүйн үйл ажиллагааны талаарх үнэт зүйл, хөгжлийн үзэл баримтлал, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ.

Нийслэлийн эрхэм зорилгыг нийгмийн өмнө хүлээсэн үүрэг ба иргэд, оршин суугчдын хүсэл сонирхлыг жолоодох асуудлуудад тулгуурлан томъёолов. Ингэхдээ бид юу хийдэг вэ? Хэнд зориулж үүнийг хийдэг вэ? Яагаад үүнийг хийдэг вэ? гэсэн гурван асуулыг чиг баримжаа болгов.



### ЭРХЭМ ЗОРИЛГО:

Нийслэлийн өмчийг эзэмших, ашиглах, хамгаалах оновчтой бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, эзэмшил, ашиглалтыг сайжруулж, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх.

### ҮНЭТ ЗҮЙЛ

- ✓ **Мэдлэгийг эрхэмлэх:** Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлнэ.
- ✓ **Чадварыг эрхэмлэх:** Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.
- ✓ **Хууль ёсыг эрхэмлэх:** Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.
- ✓ **Ёс зүйг эрхэмлэх:** Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.
- ✓ **Шударга ёсыг эрхэмлэх:** Байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.
- ✓ **Соёлтой харилцааг эрхэмлэх:** Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа, үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.
- ✓ **Үнэнч байдлыг эрхэмлэх:** Төрийн албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандаж, албан үүргээ үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог ашиглаж ажиллана.
- ✓ **Шуурхай байдлыг эрхэмлэх:** Байгууллагын үйл ажиллагааг явуулахад бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.
- ✓ **Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх:** Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.
- ✓ **Бүтээлч байдлыг эрхэмлэх:** Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.
- ✓ **Багийн ажиллагааг эрхэмлэх:** Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.



### ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний үндсэн зорилго нь нийслэлийн Өмчийн харилцааны газрын нөхцөл байдлыг судалж, үр дүнг байгууллагын 2023-2024 оны стратегийн шийдвэрийн гол үндэслэлийг томъёолоход суурь болгон ашиглах юм. Өөрөөр хэлбэл, гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх замаар хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно.

Аливаа стратегийн шинжтэй шийдвэр гаргах, төлөвлөгөө боловсруулахын тулд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг дотоод, гадаад орчныг судлах шаардлагатай болдог бөгөөд байгууллагын алсын хараа, урт хугацааны зорилтууд, стратегийн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлоход SWOT шинжилгээг ашиглалаа.

Орчны шинжилгээг хийхдээ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлоход голлон чиглэсэн ба өнгөрсөн жилийн тайлан, жил, улирлын гүйцэтгэлийн, төсөв санхүүгийн тайлангууд болон мандатын шинжилгээний хүрээнд хийгдсэн гадагш, дотогш чиглэсэн харилцааны хүрээнд холбогдогч талуудыг тодорхойлон одоогийн дүр төрхийг тодорхойлж, давуу ба сул тал, боломж, аюул заналаар дамжуулан цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлон гаргасан.

Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, НЗД-ын 2021 оны А/1040 дүгээр захирамжаар байгууллагын нэр, НЗД-ын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдсөн. Газрын даргын 2022 оны А/04 дүгээр тушаалаар дараах бүтэц, орон тоогоор ажиллаж байна.

## ХЭЛТСҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

**1.Захиргаа, Төлөвлөлт, санхүүгийн хэлтэс:***Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:*

- ✓ Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтууд, нийслэлийн өмчийн харилцааны талаар гарсан бодлого, шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлтийн явц, үр дүнг тодорхойлох,
- ✓ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, нийслэлд хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон бусад холбогдох дээд байгууллагаас гаргасан шийдвэрүүдийн биелэлтийг гаргах;
- ✓ Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэхэд итгэмжлэл олгогдсон тохиолдолд төлөөлөн оролцох, шүүхэд тайлбар, холбогдох нотлох баримт гаргаж өгөх, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- ✓ Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журам болон байгууллагын дотоодод мөрдөгдөж байгаа эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах асуудлыг бусад хэлтэстэй хамтран зохион байгуулах;
- ✓ Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсүүдийн саналыг үндэслэн, бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллахад хяналт тавих, тайлан гаргах;
- ✓ Нийслэлийн өмчийг түрээсээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах: түрээслүүлэгчийг сонгон шалгаруулах, түрээсийн гэрээ байгуулах, дүгнэх, түрээсийн гэрээг кодлуулан санхүүгийн программд нэгтгэж баталгаажуулах;
- ✓ Нийслэлийн засаг даргын захирамжаар данснаас хасагдсан барилга байгууламж, тээврийн хэрэгслийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах;
- ✓ Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын данснаас хасах шийдвэртэй татан төвлөрүүлсэн хөрөнгөнд үнэлгээ хийх, худалдан борлуулах;
- ✓ Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлага бодлого, чиглэлийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчдын сахилга дэг журам, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хүн хүчний нөөцийг зөв байршуулах, хүний хөгжлийг дээдэлсэн менежмент явуулах, хүний нөөцийн нэгдсэн системд мэдээллийг тогтмол шинэчлэн оруулах;
- ✓ Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, албан хаагчдын үйлчилгээний стандартын хэрэгжилт, ёс зүйн байдалд хяналт тавих;
- ✓ Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- ✓ Санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцсэн нэгдсэн программаар хөтлөх, санхүүгийн дотоод хяналт шалгалтыг сайжруулах, байгууллагын төсөв зохион батлуулах, батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж зохион байгуулах, ногдол ашиг, түрээсийн төлбөр, өмч хувьчлалын орлого, худалдан борлуулсан хөрөнгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх;
- ✓ Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, зөвлөмж, зохион байгуулалт, захирамжлахын баримт бичгийн стандарт боловсруулж, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлэх;
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган

ажиллаж, байгууллагын цахим хуудсыг ажиллуулж, баяжилт хийх, төрөл бүрийн чиглэлийн мэдээллийн сан байгуулах, НИТХ болон НЗД-ын зөвлөлийн хуралд өргөн барих танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн эх, танилцуулга, шторк, реклам бэлтгэх, арга хэмжээнүүдийг баримтжуулж, фото архив үүсгэх, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд оруулах;

- ✓ Байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг ханган, хэвийн тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, компьютерын гадаад дотоод сүлжээний үйл ажиллагааг хангах;

## **2. Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс**

*Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:*

- ✓ Бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, хамтран ажиллах гэрээ зэрэг баримт бичгүүдээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах талаар шаардлагатай тохиолдолд зөвлөгөө өгч ажиллах;
- ✓ Байгууллагын стратеги зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтэд хуулийн хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;
- ✓ Холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтэд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагыг мэдээллээр хангах;
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлэх ажлыг зохион байгуулах, удирдлагыг мэдээллээр хангах;
- ✓ Төсвийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, зам талбай, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах, санал өгөх;
- ✓ Нийслэлийн Засаг даргын захирамжаар эрх шилжин ирсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах;
- ✓ Эргэлтийн бус хөрөнгийн комиссын хурал зохион байгуулах;
- ✓ Хяналт, шалгалтын жилийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, тухайн жилийн турш төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийх;
- ✓ Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн өмч хөрөнгийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалт, хамгаалалтад эрх хэмжээний хүрээнд шалгалт хийн, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;
- ✓ Нийслэлийн өмчийн барилга байгууламж эзэмшигч, ашиглагчийн барилга байгууламжийн хувийн хэрэг хөтөлж, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж зориулалтын дагуу ашиглаж буй зэрэгт хяналт тавих, судалгаа гаргах, дүгнэлт, санал боловсруулж шийдвэрлэх;
- ✓ Үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;
- ✓ Төрийн болон өмчийн бусад хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага, иргэд түрээсээр эзэмшиж буй нийслэлийн өмчийн барилга байгууламжид хийх хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хянан баталгаажуулах ажлыг журамд заасны дагуу зохион байгуулах;
- ✓ Татан буугдсан, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон байгууллагуудад гарсан зөрчил, маргааныг судалж хуулийн дагуу шийдвэрлүүлэх;
- ✓ Байгууллагын тайлан балансад бүртгэлтэй барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалт, данснаас хасагдсан хөрөнгийн үйл ажиллагаа, өмч хувьчлал, тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаанд хяналт тавих;
- ✓ Удирдлага болон өөрийн санаачлагчаар хэлтэс, нэгж, албан хаагчдын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг арилгуулах, дахин гаргахгүй байх, гарахаас урьдчилан сэргийлэх талаар

холбогдох албан тушаалтанд хандаж хугацаатай үүрэг даалгавар, санал зөвлөмж өгөх, биелэлтийг хангуулах, холбогдох албан тушаалтан биелүүлээгүй тохиолдолд түүнд хууль, тогтоомжийн хүрээнд сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг удирдах албан тушаалтанд танилцуулах;

- ✓ Байгууллагаас зохион байгуулсан сонгон шалгаруулалт болон түрээсийн гэрээний биелэлтэд хяналт тавих;
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өмч хөрөнгийн холбогдолтой өргөдөл, гомдол, маргааныг судлах, холбогдох шийдвэр гаргуулах, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явцад хяналт тавих;

### 3. Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:

- ✓ Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудад төрөл бүрийн эх үүсвэрээр шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг журмын дагуу зохион байгуулах;
- ✓ УИХ-ын тогтоолоор нийслэлийн өмчлөлд шилжин ирж, төсөвт байгууллагын эзэмшилд очих эд хөрөнгийг хүлээн авах, бүртгэх;
- ✓ Улсын, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх болон хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын судалгаа гаргах;
- ✓ Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллого, дахин үнэлгээний нийслэлийн хэмжээний нэгтгэлийг гаргах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх, мэдээллийн системийн өгөгдлийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаас баталсан маягтуудын дагуу мэдээ мэдээллийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- ✓ Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн мэдээллийг Өмчийн мэдээллийн системд бүрэн гүйцэд оруулах, шинэчлэх, холбогдох өөрчлөлт хийх ажилд хяналт тавих, зохион байгуулах;
- ✓ Нийслэлийн өмчийн талаар лавлагаа олгох;
- ✓ Нийслэлийн өмчид шинээр бүртгэсэн эд хөрөнгөтэй холбоотой баримт бичгийг архивлах;
- ✓ Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын удирдлагатай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулах, дүгнэх;
